

Хөгжмийн багшийн түүвэрт сонгогдсон хүүхдийн гүйцэтгэх даалгавар-багшид

<b>Даалгаврын дугаар:</b> 1	<b>Бүлэг:</b> Дунд	
<b>Хөгжлийн чиглэл:</b> Танин мэдэхүй	<b>Сургалтын чиглэл:</b> Хөгжим	
<b>Сургалтын хөтөлбөрийн чадварын түвшин:</b> II	<b>Танин мэдэхүйн түвшин:</b> Сэргээн санах	
<b>Илрүүлэх чадвар:</b> Өөрийн мэдэг дуу болон хөгжмийн алгууг сонсоод нэрлэх._	<b>Интеграци эсэх:</b> Үгүй	
<b>Даалгаврыг гүйцэтгэх хугацаа:</b> Гүйцэтгэлээр	<b>Даалгаврын хэлбэр:</b> Задгай	
<b>Даалгавар</b>	<p>“Энэ ямар нэртэй дуу вэ?”                  Жишээ дуу:                  1. <a href="https://www.youtube.com/watch?v=22WI79OhHrU">https://www.youtube.com/watch?v=22WI79OhHrU</a>                  2. <a href="https://www.youtube.com/watch?v=jo9ygVoRUGs&amp;t=13s">https://www.youtube.com/watch?v=jo9ygVoRUGs&amp;t=13s</a></p>	
<b>Хэрэглэгдэхүүн</b>	Даалгаварт өгөгдсөн дууг багш тухайн бүлэгт заагаагүй тохиолдолд багшийн заасан дууны жагсаалтаас сонгоно.	
<b>Даалгаврын заавар</b>	Багш хоёр дууны эхлэл, дахилтыг сонгоно. Эхний дууг сонсоод хүүхдүүдээс ямар нэртэй дуу болохыг асууна. Дараагын дууг сонсоод хүүхдүүдээс ямар нэртэй дуу болохыг асууна.	
<b>Даалгаврыг явуулах аргачлал</b>	<i>Багшийн хэлэх үг</i>	<i>Багшийн хийх үйлдэл</i>
	<ul style="list-style-type: none"> <li>- Багш нь нэг дуу сонсоё. Анхааралтай сонсоорой.</li> <li>- Энэ ямар нэртэй дуу вэ? Чи мэдэх үү? Багшдаа нэрийг нь хэлээрэй.</li> <li>- Багш нь дахин өөр дуу сонсоё. Анхааралтай сонсоод дууны нэрийг нь хэлээрэй.</li> </ul>	Багш энхий дууг сонгоно. Багш дараагын дууг сонгоно. /Хүүхэд дууны нэрийг хэлээгүй хмэдэхгүй эргэлзсэн бол дууг дахин нэг удаа сонгоно./
<b>Дэмжлэг</b>	Хүүхэд дууг сонсоод нэрийг нь хэлэхгүй байвал джж тус бүр дээр 2 удаа дөхүүлэх асуулт асууж нэг удаа дэмжлэг үзүүлнэ.	
<b>Анхаарах зүйл</b>	Багшийн заасан дууны жагсаалтаас дууг зөвхөн үнэлгээний баш, гишүүд сонгоно. Хүүхэд сонголын ажиглалт хийж үйлдлийг хийх хугацааг олгоно. Яаруулахгүй хүлээцтэй байна. Хүүхэд өөрийнхөөрөө чөлөөтэй байх орчныг бүрдүүлэхэд анхаарна.	

<b>Даалгаврын дугаар: 2</b>		<b>Бүлэг: Дунд</b>	
<b>Хөгжлийн чиглэл: Танин мэдэхүй</b>		<b>Сургалтын чиглэл: Хөгжим</b>	
<b>Сургалтын хөтөлбөрийн чадварын түвшин: II</b>		<b>Танин мэдэхүйн түвшин: Задлан шинжлэх</b>	
<b>Илрүүлэх чадвар: Дуу дуулахдаа өөрийгөө болон найз нөхөдийгөө сонсож зэрэг дуулна.</b>		<b>Интеграци эсэх: Үгүй</b>	
<b>Даалгаврыг гүйцэтгэх хугацаа: Гүйцэтгэлээр</b>		<b>Даалгаврын хэлбэр: Задгай</b>	
<b>Даалгавар</b>	"Бид дуучин"		
<b>Хэрэглэгдэхүүн</b>	Сонгосон дууны фонограмм эсвэл даралтад хөгжим, төгөлдөр хуур ашиглана.		
<b>Даалгаврын заавар</b>	Багш хүүхдэд дууг сонсоно. Ямар дуу болон дуунд юу гарч байгаа талаар ярилцана. Дууг дуулахдаа зэрэг эхэлж, зэрэг төгсгөнө. Дуулах явцдаа найз нөхөдөө сонсож дуулахыг хэлж өгнө.		
<b>Даалгаврыг явуулах аргачлал</b>	<i>Багшийн хэлэх үг</i>		<i>Багшийн хийх үйлдэл</i>
	<ul style="list-style-type: none"> <li>- Дууг сонсоод нэрлээрэй.</li> <li>- Дуунд юуны тухай гарч байна вэ?.</li> <li>- Найзуудтайгаа дуугаа дуулаарай.</li> <li>-Дуулах явцдаа найзуудаа сонсож дуулаарай.</li> </ul>		Хоолойтой дууны бичлэгийг сонсоно. Хүүхдүүд дууг дуулахад хоолойгүй бичлэгийн 1,2 дугаар байдгийг сонгоно. Дууг 1 удаа дуулна.
<b>Дэмжлэг</b>	Хэмжээ алдсан, өнгө алдсан зарим шаардлагатай үед төгөлдөр хуур хөгжмөөр аялгууг тоглож дэмжлэг үзүүлнэ. Хүүхэд дуулж чадахгүй байгаа бол багш тохирох дэмжлэгийг үзүүлнэ.		
<b>Анхаарах зүйл</b>	Үнэлгээний багийн гишүүд дууг сонгохдоо багшийн өмнө заасан дууны жагсаалтаас сонгоно. Гурван хүүхэд хамт дуулна.		

<b>Даалгаврын дугаар: 3</b>		<b>Бүлэг: Дунд</b>
<b>Хөгжлийн чиглэл: Танин мэдэхүй</b>		<b>Сургалтын чиглэл: Хөгжим</b>
<b>Сургалтын хөтөлбөрийн чадварын түвшин: II</b>		<b>Танин мэдэхүйн түвшин: Ойлгох</b>
<b>Илрүүлэх чадвар:</b> Багшийг дагаж хэмнэлийн дагуу алга таших, ширээн дээр товших, зэргээр мэддэг дууныхаа хэмнэлийг гаргаж тоглоно.		<b>Интеграци эсэх: Үгүй</b>
<b>Даалгаврыг гүйцэтгэх хугацаа: Гүйцэтгэлээр</b>		<b>Даалгаврын хэлбэр: Задгай</b>
<b>Даалгавар</b>	“Хэмнэлээр наадъя”	
<b>Хэрэглэгдэхүүн</b>	<a href="https://www.youtube.com/watch?v=6oysYOo34Fk">https://www.youtube.com/watch?v=6oysYOo34Fk</a>	
<b>Даалгаврын заавар</b>	Хэмнэлийн бичлэгийг хүүхдэд үзүүлнэ. Алга таших, өвдгөө цохих, цээжээ товших хөдөлгөөнийг хийж үзүүлнэ. Хүүхдүүдтэй хамтдаа хэмнэлд тохируулан хийнэ.	
<b>Даалгаврыг явуулах аргачлал</b>	<i>Багшийн хэлэх үг</i>	<i>Багшийн хийх үйлдэл</i>
	- Багш нь бичлэг үзүүлнэ. Анхааралтай үзээрэй. - Хэмнэлийг багшийгаа /бичлэгийг/ дагаад хийгээрэй.	Багш хэмнэлийг 1 удаа биечлэн хийж үзүүлнэ. Хүүхдүүдийг дагуулан хэмнэлээр тоглоно.
<b>Дэмжлэг</b>	Хүүхэд үйлдэл хийхгүй байх тохиолдолд багш хэмнэлийн дагуу үйлдлийг дагуулан нэг удаа хийнэ.	
<b>Анхаарах зүйл</b>	Хүүхдийг яаруулахгүй хүлээцтэй байна. Даалгаврыг хоёр хүүхэд зэрэг гүйцэтгэнэ.	

<b>Даалгаврын дугаар: 4</b>		<b>Бүлэг: Дунд</b>
<b>Хөгжлийн чиглэл: Танин мэдэхүй</b>		<b>Сургалтын чиглэл: Хөгжим</b>
<b>Сургалтын хөтөлбөрийн чадварын түвшин: II</b>		<b>Танин мэдэхүйн түвшин: Ойлгох</b>
<b>Илрүүлэх чадвар: Дүрс бичлэг үзэж, бүжгийн хөдөлгөөнийг дуурайж хийнэ.</b>		<b>Интеграци эсэх: Үгүй</b>
<b>Даалгаврыг гүйцэтгэх хугацаа: Гүйцэтгэлээр</b>		<b>Даалгаврын хэлбэр: Задгай</b>
<b>Даалгавар</b>	“Бүжиглээрэй”	
<b>Хэрэглэгдэхүүн</b>	<a href="https://www.youtube.com/watch?v=DMW69KSaO4o">https://www.youtube.com/watch?v=DMW69KSaO4o</a>	
<b>Даалгаврын заавар</b>	Бичлэгийг хүүхдэд үзүүлнэ. Хүүхдүүд бичлэгийг дагаж бүжгийн дасгалыг хийнэ.	
<b>Даалгаврыг явуулах аргачлал</b>	<b>Багшийн хэлэх үг</b>	<b>Багшийн хийх үйлдэл</b>
	<ul style="list-style-type: none"> <li>- Багш нь нэг бүжгийн хөдөлгөөн хөдөлгөөнийг үзүүлнэ. Анхааралтай үзээрэй.</li> <li>- Багш нь бүжгийн хөдөлгөөнийг хийж үзүүлнэ. Багшийгаа яаж бүжиглэж байгааг анхааралтай хараарай.</li> <li>- Одоо чи энэ бичлэгийг/багшийгаа дагаад бүжгийн хөдөлгөөнийг дагаад хийгээрэй.</li> </ul>	Багш бичлэгийг үзүүлнэ. Багш нэг удаа биечлэн хийж үзүүлнэ.
<b>Дэмжлэг</b>	Хүүхэд бүр, өөрийн сэтгэгдлээ чөлөөтэй илэрхийлэх боломжийг олгоно. Даалгаврыг ойлгоогүй хүүхдэд дахин тайлбарлаж өгнө. Хүүхэд хөдөлгөөн хийхгүй зогссон үед л багш хөдөлгөөнийг дагуулан хийж чиглүүлж өгнө. Ингэхдээ багш дуустал дагуулан хийлгэхгүй. Хүүхэд хөдөлгөөнийг дагаж хийгээд эхлэх үед багш дэмжлэгийг зогсооно.	
<b>Анхаарах зүйл</b>	Хүүхэд бичлэгийг үзэж бүжгийн хөдөлгөөнийг дуурайж хийнэ.	